

ТЕМПЕРАМЕНТ ТОДОРХОЙЛОХ ТЕСТ

Мэдрэлийн тогтолцооны хэв шинж болон темпераментийг тодорхойлох нь манай тооллын өмнөөс олон эрдэмтдийн сонирхолыг татаж, судалсаар иржээ. Темпераментийн сэтгэл зүйн сонирхолтой тодорхойлолтыг 18-р зуунд Германы нэрт философич Кант дэвшүүлсэн байна.

Заавар: Судалгааны хуудасны 4 хэсэг дэх 20 шинжүүдийг уншаад өөртөө байгаа шинжийн ард “+” тэмдэг тавина. Хэрэв энэхүү шинж илэрдэггүй бол “-” тэмдэг тавина.

№	Асуулт	Тэмдэг
1	Тогтворгүй, байнга хөдөлгөөнтэй, гар хуруугаараа ямар нэг юм үргэлж оролддог.	
2	Омогтой, ширүүн ууртай.	
3	Тэвчээргүй, биеэ барьж чаддаггүй.	
4	Шийдэмгий, санаачилгатай.	
5	Зөрүүд.	
6	Маргаанд цэцэн, дийлэх гэж тэмцэлдэх хандлагатай.	
7	Үе, үе гэнэт үсрэнгүй байдлаар түргэн ажилладаг.	
8	Хүмүүстэй харьцахдаа ний нуугүй шууд, шулуун хурц.	
9	Аз үзэх, аз мэдэн турших дуртай.	
10	Өсөрхөж, уурлаж гомдох нь түргэн.	
11	Сэтгэлийн хөдөлгөөнтэй, огцом түргэн хэл яриатай.	
12	Хэрүүлч, зодоонч.	
13	Бусдын дутагдлыг тэвчиж чаддаггүй.	
14	Түрэмгий дээрэлхүү, захирах тушаах дуртай.	
15	Гар, нүүрний хөдөлгөөн ихтэй.	
16	Түргэн бодож шийдвэрлэх чадвартай.	
17	Шинэ зүйлд дасахдаа удаан.	
18	Тавьсан зорилгодоо хүрэхдээ тууштай.	
19	Алхаа гишгээ огцом түргэн.	
20	Ааш зан нь эрс, амархан өөрчлөгдөж хувьсдаг.	

Дээрх асуултын 16-20-д нь /+/ бол цэвэр Холерик.

№	Асуулт	Тэмдэг
1	Хөгжилтэй, баяр баясгалантай, тачигнатал чанга инээдэг.	
2	Эрч хүчтэй, ажилсаг байж чаддаг.	
3	Эхэлсэн зүйлээ дуусгалгүй орхих нь цөөнгүй.	
4	Өөрийгөө хэт үнэлдэг.	
5	Шинэ юмыг түргэн ойлгож, хүлээн авч амархан тусгаж авдаг.	
6	Сониуч, харилцаа тогтворгүй.	
7	Эвгүй, золгүй муу юманд зовж шаналах нь бага.	
8	Янз бүрийн нөхцөлд түргэн дасаж зохицож нийцдэг.	
9	Аливаа шинэ ажлыг сонирхон дуртай эхэлдэг.	
10	Сонирхолгүй зүйлд амархан дургүй нь хүрч хөндийрч хөрдөг.	
11	Ажилд идэвхитэй оролцдог ба нэг ажлаас нөгөөд амархан шилжин хийж чаддаг.	
12	Бусдыг уриалан зохион байгуулах дуртай.	
13	Нийтэч, уриалгахан шинэ хүмүүсийн дэргэд нэрэлхэж эмээдэггүй.	
14	Тэсвэртэй, тууштай ажиллах чадвар сайн.	
15	Нүүр, гарын хөдөлгөөн их оролцсон, чанга түргэн, тод хэл яриатай.	
16	Гэнэтийн төвөгтэй нөхцөлд биеэ барьж чаддаг.	
17	Ямагт цовоо сэргэлэн ааль араншинтай.	
18	Түргэн унтаж, амархан сэрдэг.	
19	Эмх цэгц муутай, замбараагүй юмыг яарч шийдвэрлэх талтай.	
20	Заримдаа өнгөц хийсвэр хандлагатай.	

Дээрх асуултын 16-20-д нь /+/ бол цэвэр Сангвиник.

№	Асуулт	Тэмдэг
1	Эмх журамтай, нямбай.	
2	Юманд ул суурьтай ханддаг.	
3	Болгоомжтой, бодлоготой.	
4	Хүлээцтэй.	
5	Хоосон чалчих дургүй, дуу цөөнтэй.	
6	Сэтгэл хөдлөл багатай, жигд тогтуун хэл яриатай.	
7	Тайван, удаан хөдөлгөөнтэй, нүүр гарын хөдөлгөөн бага.	
8	Юмыг удаан ойлгож сайн тогтоодог.	
9	Эхэлсэн хэргийнхээ эцсийг үздэг.	
10	Хүч чадлаа хоосон зарцуулдаггүй.	
11	Амьдрал ажилдаа хэвшсэн дэг журмаа хатуу барьдаг.	
12	Сэтгэл догдлолоо амархан барьдаг.	
13	Сайшаал, шүүмжлэлд эмзэг мэдрэмтгий биш.	
14	Өөрийг нь дооглох, шоглохыг үл тоомсорлодог.	
15	Сонирхол, харилцаа тогтвортой.	
16	Ажилд орох, нэг юмнаас нөгөөд шилжилт хийхдээ удаан.	
17	Хүн бүртэй жигд харилцаатай.	
18	Шинэ нөхцөлд дасаж зохицохдоо бэрхшээдэг.	
19	Зовлон, өвчин тэсвэр тэвчээртэй.	
20	Уур уцааргүй.	

Дээрх асуултын 16-20-д нь /+/ бол цэвэр Флегматик.

№	Асуулт	Тэмдэг
1	Ичимхий бүрэг.	
2	Шинэ нөхцөлд тэвдэж сандардаг.	
3	Танихгүй хүмүүстэй холбоо тогтоохдоо бишүүрхэж, бэрхшээдэг.	
4	Өөрийн хүчинд итгэдэггүй.	
5	Ганцаардлыг амархан давдаг.	
6	Ажил, амьдарлын бүтэлгүй, амжилтгүй тохиолдолд гутарч сэтгэлээр амархан унадаг.	
7	Бодлогширч гиюүрэх талтай.	
8	Амархан ядардаг.	
9	Сулхан, аяархан хэл яариатай.	
10	Ярьж байгаа хүнийхээ зан төлөвт зохицдог.	
11	Өрөвчхөн, эмзэг уян сэтгэлтэй.	
12	Сайшаал, шүүмжлэлд маш их мэдрэмтгий.	
13	Өөртөө болон бусад хүмүүст өндөр шаардлага тавьдаг.	
14	Хардаж сэрдэх талтай.	
15	Өвчин зовлонд эмзэг.	
16	Хэтэрхий гомдомтгой.	
17	Хэнтэй ч өөрийн бодол санааг хуваалцдаггүй, нийтэч биш.	
18	Идэвх санаачилга бага, бүрэг.	
19	Дуулгавартай, хүлцэнгүй.	
20	Бусдаар өрөвдүүлэх дургүй.	

Дээрх асуултын 16-20-д нь /+/ бол цэвэр Меланхолик.

Үр дүнг боловсруулах:

Хэрэв тухайн хэсгийн асуултыг 16-20-д нь “+” тависан бол тухайн төрлийн темперамент цэвэр илэрнэ. 11-15 байвал тухайн темпераментийн шинж түлхүү илэрдэг. Хэрэв 6-10 бол энэ темпераментийн шинж тун бага илэрч байгааг илтгэнэ.

1. 4 хэсгийн 20 шинжүүдийг өөрт илэрдэг эсэхийг тодорхойлон “+” эсвэл “-” тэмдэг тавиад хэсэг тус бүр дэх нэмэх тэмдгийг тоолно.

Тооны харьцаанаас шалтгаалан та өөртөө дүгнэлт хийнэ. Жишээ нь: Сангвиник 14, холерик 14, бусад хоёр шинж нь арваас доош оноо авчээ гэж үзвэл сангвиник, холерик хосолсон хэв шинжийн хүн гэж тодорхойлж болно. Харин сангвиник 15, флегматик 13, холерик 6, меланхолик 5 оноо авсан бол та сангвиник давамгайлсан флегматик гэж дүгнэж болно.

2. Темперамент бүрийн илрэлийн харьцааг дараах томъёогоор бодож гаргана.

$$X = \frac{A_1 \times 100}{A}; \text{ Холерикийн хувь}$$

$$C = \frac{A_2 \times 100}{A}; \text{ Сангвиникийн хувь}$$

$$F = \frac{A_3 \times 100}{A}; \text{ Флегматикийн хувь}$$

$$M = \frac{A_4 \times 100}{A}; \text{ Меланхоликийн хувь}$$

Темпераментийн онцлог

Сангвиник /*сэргэлэн араншин*/: Гавшгай сэргэлэн, юм юмыг сонирхдог сэтгэлийн хөдөлгөөн нь гүнзгий биш, цовоо сэргэлэн бөгөөд нийтэч, ажил амьдралд хүртээмжтэй, хүмүүстэй танилцахдаа амархан, орчиндоо хандах нь идэвхитэй, хэнэггүй занд дургүй. Харин олон зүйлд самгардах, зарим үед хөнгөмсөг байдал гаргах дутагдал бий.

Холерик /*тогтворгүй дайчин араншин*/: Цочмог, шаралхуу, хурц бөгөөд хурдан омголон зантай, түргэн ааштай, дүрсхийн огцом уурлах нь цөөнгүй, тогтворгүй боловч дайчин байдалтай, урам зориг нь хувирахдаа хурдан, орчиндоо маш идэвхитэй ханддаг. Холерик хүн мэдрэл, сэтгэлийн хувьд ядрах нь бага, ажил үйлст эрч хүч сайтай, хөнгөн гавшгай юм.

Флегматик /*тайван араншин*/: Хүчтэй хэв шинжийн боловч хөөрөл саатлын хөдөлгөөн, солигдол нь удаан буюу хөшүүн. Тайван, дөлгөөн, тогтуун байдалтай, дуу цөөн, биеэ хянан барьдаг, сэтгэлийн гадаад илрэл нь сул буюу бүдэг. Харин ажлын чанар нь сайн, аливаа асуудалд буурь суурьтай хандах нь их.

Меланхолик /*сул араншин*/: Буурь суурьтай, дүнсгэр зан бөгөөд зарим талаар бүрэг ноомой, гунигтай байдалтай болдог. Хянуур боловч зөөлөн, уриалгахан зан энэ хэв шинжийн хүмүүст бий. Эмзэг сэтгэлтэй, бага ч гэсэн бүтэлгүй явдалд дургүйцэн сэтгэл санаа нь зовох нь их. Орчиндоо хандах сэтгэл хөдлөл бага. Зожиг, айх эмээх нь цөөнгүй, орчиндоо зохицох нь удаан, ядрамтгай байдалтай болох нь олонтаа ч ажлын бүтээмж нь чанартай, юманд нямбай хичээнгүй ханддаг. Маш өндөр мэдрэмжтэй тул аливаа юмны сайн мууг мэдрэн ойлгохдоо амархан, үнэлэн дүгнэх чадвар сайтай байдаг.